

МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШНЫ ХОЁР ДАХЬ ДЭЛГЭРЭЛТИЙН ХУРААНГУЙ

Б.Түшихбаяр - МУИС. НШУС. Шашин Судлалын Тэнхимийн докторант

Түлхүүр үг: Хоёр дахь дэлгэрэлт. Уг сурвалж, Төрийн шашин, Сувдан зарлиг, Монголын хаад.

Товч утга: Монгол оронд Бурханы шашин хэд хэдэн мөчлөгөөр дэлгэрч байжээ. Энэхүү өгүүлэлд тэдгээр дэлгэрэлтийн дунд үеийн тухайд онцлон авч үзэж байна. Энд өгүүлэгдэх хоёр дахь дэлгэрэлтийн уг сурвалж хийгээд төрийн шашин болсон онцлог байдал, цаашдын үйл явцын талаархи гол үндэслэлийн тухайд зохиогч өөрийн үзэл баримтлалаа илэрхийлжээ.

Монгол орноо Бурханы шашин гурвантаа дэлгэрсэн гэж Монголын Бурханы шашны түүхийн номуудад олонтоо бичсэн байдаг. Тэдгээрийн нэг нь XX зууны эхэн үеийн эрдэмтэн, түүхч Заваа Дамдин гавжийн “Алтан дэвтэр” номонд тодорхой өгүүлсэн байгаа билээ. Түүнд анхдугаар дэлгэрэлт нь монголчуудын анхны төрт улс болох Хүннү, хоёрдугаар нь, Юань гүрний үед, гуравдугаар нь Алтан ханы үед Төвдийн III Далай лам Монгол оронд заларч шашин дэлгэрүүлсэнтэй холбон авч үзсэн байна.

Монгол оронд Бурханы шашин дэлгэрсэн анхны ба гуравдугаар дэлгэрэлт нь үндсэн эх газар нутагтаа дэлгэрсэн байдаг бол хоёрдугаар дэлгэрэлт нь Хятад дахь Монголын Юань гүрэнд буюу Бээжин хотноо хааны ордны хүрээнд дэлгэрсэн өвөрмөц онцлог ажиглагддаг.

1. Шинэ дэлгэрэлтийн уг сурвалж

Бурханы шашны хоёрдугаар дэлгэрэлтийн анхдагч гарал үүслийн тухайд авч үзвэл энэ нь юуны өмнө Чингис хаан (1162-1227 он) Их Монгол улсыг үүсгэн байгуулсантай холбогдоно. Энэ үйл явцтай холбоотой гурван зүйлийг тодруулах шаардлага гарна.

1. 1206 онд Онон мөрний эхэнд Монголын ихэс дээдэс, язгууртнууд Их хурилдай чуулганаар Тэмүүжинг Чингис хаанд өргөмжлөн Их Монгол улсын хаан ширээнд суулгаснаар Их Монгол улс байгуулагдсан нь Монгол орон хүчирхэг болох үндэс бий болсон юм.

2. Чингис хаан гадаад, дотоод шалтгааны улмаас олон орныг байлдан дагуулах үйл ажиллагаа явуулсан юм. Үүний үр дүнд хожим нь 1260 оны үе гэхэд Хүлэгү Ираны нутагт Иль хаант улсыг (1256-1265 он) байгуулж, энэ бүс нутагт хаан болж, Зүчийн угсааныхан Орос орчимд Алтан ордны улсыг байгуулсан, Цагаадайн угсааныхан Дундад азийн бүс нутагт, харин уугуул нутаг Хархорум хотноо Мөнх хаан 1259 онд Сүн улстай байлдаанд яваад таалал болохдоо Аригбөхөөр нутгаа захируулан үлдээсэн байлаа.

3. Монголын их хааны суудлыг Мөнх хаан (1251-1259 онд хаан байсан) залгамжлахдаа Хархорум хотыг Монгол орны нийслэл болгосон байсан нь тэрээр эзлэн нэгтгэсэн улс орнууддаа ямар бодлого баримтлахаас хамааран

азийн төвд нүүдэлчдийн байгуулсан улсын шашны бодлого шалтгаалах болсон байлаа. Бурханы шашны хоёрдугаар удаагын дэлгэрэлт нь Монголын улс төрийн дээрх хүчин зүйлээс хамаарсан юм.

Үнэн хэрэгтээ, Монгол нутагт Хархорум хот байгуулагдсан нь тэдгээр улсуудын нэгдсэн бодлогийг зохицуулах төв болж байсан юм. Монголчууд евроазийн өргөн бүс нутагт ноёрхлоо тогтоох болсноор эх нутаг Монгол орон гадаад, дотоодын иргэдийн анхаарлын төвд орсноор ахар богино хугацаанд Хархорум хот нь худалдааны бүс нутаг буюу олны хөлийн газар болжээ. Энэ үед Монгол орноор жуулчилсан Францын жуулчин Гильом де Рубруккийн "Монголоор аялсан тэмдэглэл"-д Хархорум хотод Бурханы, Мусульманы, Христын зэрэг 12 сүм байсан тухай бичсэн байна. Энэ тухай нэгэн баримтыг иш татвал "Өгөөдэй хаан 1220 онд Чингис хаан улсын нийслэл болгосон хотод том суврага бариулж эхэлсэн, Хар хорум хотын хэрэм дотор барьсан том сүмд сахалгүй, шар хувцас өмссөн олон лам нар эрхи барин, өөд өөдөөсөө харан хоёр эгнэн "ум ма ни бад мэ хум" гэж уншин сууж байжээ (12). Мөн "XIV зууны эхний хагаст босгосон монгол хөшөөны бичээсэнд лам нарын суух 120 хийд барьсан тухай дурдсан зэргээс үзэхэд"⁷⁰ гэснээс үзэхэд энэ үед Монгол оронд хэд хэдэн шашин нэгэнт зэрэгцэн оршин тогтносон байлаа.

Иймээс Хархорум хотын энэхүү шашны байдал төрх нь Монгол оронд Бурханы шашин дэлгэрэх уг сурвалж болсон гэж үзэж байна.

2. Хубилай хаан Бурханы шашныг төрийн шашин болгосон нь

Хубилай хаан 1260 оны 6-р сард Шанду хотод Монголын хаан хэмээн өргөмжлөгдөн хаан ширээнд суусан тэр үеэс Хархорум хот аажимдаа эх нутгаасаа өмнө зүг рүү шилжих шилжилт болсон юм. Энэ талаар түүхч Ч.Далай "Хубилай Монголын нийслэлийг нүүлгэх төлөвлөгөөг маш нарийн дэс дараалалтай хэрэгжүүлсэн нь тодорхой байна. Монголын нийслэлийг нүүлгэхдээ эхлээд 1260 онд Хархорумаас Кайпин руу, дараа нь 1264 онд Кайпингаас Янь-жин (Бээжин) руу тус тус шилжүүлэн нүүлгэсэн байна"⁷¹ гэснээс үзэхэд Хубилай хаан тухайн үед Хархорум хотод Монголын хаан гэж өөрийгөө өргөмжилсөн Аригбөх түүнтэй 1260-1264 онуудад тэмцэлдэж нэг улс хоёр хаантай болоод байсны улмаас Монгол улсын нийслэл Бээжин хотод төвлөрөх шалтгаан болсныг энд дурдах нь зүйтэй.

Их Монгол орны цаашдын хувь заяа цаашид хэрхэх нь тухайн үеийн улс төрийн бодлоготой холбоотой байсан тул Хятад оронд Монголын нэгдсэн улс орших болсонтой холбоотой том улсад цөөн хүн амтай жижиг улсын үйл ажиллагааг хэрхэн зохицуулснаар хадгалж үлдэх улс төрийн бодлого боловсруулсан юм. Энэ бодлого нь шашны салбарт юуны өмнө хэв загвараа тогтоосон юм. Хубилай хаан Төвдийн Бурханы шашныг талархан хүлээн авчээ. Энэ нь хэд хэдэн шалтгаантай гэж үзэж болохоор байгаа юм. Юуны өмнө,

⁷⁰ Гильом де Рубрук. "Дорно этгээдэд зорчсон минь". Улаанбаатар хот. 1988 он -р тал.

⁷¹ Ч.Далай. Юан гүрний үеийн Монгол. УБ хот. 1973 он. 44-р тал.

Чингис хаан Төвдийн Буддизмыг талархаж байсан баримт Дармадалайн "Монголд Бурханы шашин дэлгэрсэн түүх"-нд байна. Түүнд "Дөчин дөрөвтэйдээ, Төвдийн төв оронд очих цагт Дисрид жогоо ба Цалба Гунгаадорж тэргүүтэн талархан угтаж агуу их баяр хуримыг хийгээд Арийн гурван аймаг, Үй- зангийн дөрвөн хошуу, Амдо, Хам, Ган гурвыг өргөжээ"⁷² гэсэн ийм нэг ишлэл байна. Үүнд судлаачид шүүмжлэлтэй хандаж Чингис хаан Төвд оронд очоогүй гэсэн байр суурь баримталсан байдаг. Харин "Сабан Гунгаажанцанд бэлэг, захидлын хамтаар бариулж хүн илгээгээд одоогоор улс төрийн үйлс зарим нэгэн цэргийн ажил дуусаагүй тул түүнийг дуусах үед та олон шавийн хамт манай Монгол оронд заларч Бурханы шашныг мандуулж хайрлах хэрэгтэй гэж байсан байна. Иймд хаан Чингис Сажа бандидатай жинхэнэ ёсоор учрааагүй боловч холоос ламд барьж Төвдийн бүх хуврагийг албанаас чөлөөлж, Үй-зангийн олон нутгаар өргөл хүндлэл өргөж шашны их өглөгийн эзэн болжээ" гэсэн энэ нь харин илүү бодит үндэслэлтэй зүйл юм.

Төвд, Монголын энэ үеийн харилцааны байдлыг авч үзвэл Мөнх хаан Монголын их хаан ширээнд сууж байх үед ихээхэн өргөжих үндэслэл тавигдсан болох нь түүхэн сурвалжийн баримтнаас тодорхой байна. "Хубилай өөрийн ах Мөнх хааны зарлигаар Монголын хааны ивээлд багтахар харилцан өрсөлдөж байсан хоёр бүлэг болох Буддын шашинтан ба Даосын үзэлтэн нарын хооронд хэд хэдэн удаагын ширүүн маргааныг зохион байгуулж байсныг дурьдууштай байна. Ийнхүү Хубилайн дэмжлэг нь Бурханы шашинтнууд эсрэг талаа ялан дийлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бөгөөд 1258 онд Кайпин хотноо Хубилай зохион байгуулж, Пагва лам голлох үүрэг гүйцэтгэсэн сүүлчийн маргаан дээр Даосын үзэлтэн нар ялагдсан тухай Монголын хаан албан ёсоор тунхаглав.⁷³ Энэхүү түүхэн үйл явдал хожим Юань гүрэн байгуулагдах үед Төвдийн Бурханы шашин Монголын төрийн шашин болох үндэс болжээ.

Хубилай хаан 1260 онд Монгол улсын хаан ширээнд суумагцаа Пагва ламыг улсын багшаар өргөмжилж, "Их эрдэнэ, номын багш" гэсэн цол, мөнгөн тамга хүртээжээ. Хаан, хатан болон шадар түшмэд, ноёд Пагва ламаас ном хүртэж, Бурханы шашинд эхлэн оржээ. Ийнхүү Пагва лам хэмээн алдаршсан Лодойжанцан Юань улсын анхны их багш болсон юм.

Энд Пагва ламын талаар бага зэрэг тодруулж болох юм. Түүний эцэг нь Содномжалцан гэгч байсан ба тэрээр эцгийнхээ 52 насанд буюу 1235 онд мэндэлжээ. "Арван настайдаа хойд Хятад дахь Годан хааны хувь газар Сажа банчиныг дагалдан хүрэлцэн ирсэн 18 настайгаасаа хаан хүү Хубилайн тахилын лам, 21 настайдаа шашны дээд сахил хүртжээ. 1260 онд буюу 26 настайдаа Хубилайг хаан ширээнд залахад Эзэн хааны багш болжээ. Тэрээр хэд хэдэн удаа Төвдөд очиж байсныг эс тооцвол он удаан жил нийслэл хотдоо

⁷² Дармадала. Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч Цагаан лянхуан эрхис хэмээх оршвой. "Билгийн гэгээ цуврал. УБ хот. 1995 он. 44-р тал.

⁷³ Ш.Бира. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. III Дэвтэр. Хубилай хаан ба Пагва лам. 158-р тал.

амьдарсаар 1280 онд 45 насандаа таалал төгсчээ.⁷⁴ Пагва лам Монголын Юань гүрний багш байсан гэдгийн цаана тухайн хувь хүн монголчуудын хоорондын харилцаа ямар байсны талаар академич Ш.Бира тодруулсан байна. “Бидний төвд эх сурвалжуудаас олсон мэдээнээс үзэхэд Пагва лам бүр анхнаасаа Хубилай хааны хамгийн итгэлтэй зөвлөгч нь болсон бөгөөд Монголын хаан түүнийг тодорхой зорилготойгоор тусгайлан бэлтгэж байсан ажээ. Тэрээр монголчуудтай туйлын ойр дотно байсан учир Монголын хэв заншилд хүртэл орсон байв. Үүгээр үл барам Пагва лам ба Хубилай хаан хоёр нь ураг төрлийн дотно харилцаатай болж, түүний дүү, ач буюу дүүгийн хүү болон мөн түүний гуч нь монгол хаадын охидтой гэрлэж байжээ”.

Ийнхүү Хубилай хаан Пагва ламыг төрийн багш болгосноор Монголын Бурханы шашны хоёрдугаар дэлгэрэлт эхэлсэн байна. Пагва лам Монголын Юань гүрний багш болж хааны ордны дотор Бурханы шашныг дэлгэрүүлээд зогсохгүй түүний айлдварыг Хубилай хаан үйл ажиллагаанд тусгаж байснаар Юань гүрний Монгол нь эртний Энэтхэгийн хос ёсны уламжлалыг хэрэгжүүлж байсан гэдэг. Хубилай хааны зарлигаар Пагва лам 1269 онд монгол хэлний авиа зүйн онцлог, төвд үсгийн бичлэгт тулгуурлан дөрвөлжин үсэг зохиосон билээ. Хубилай хааны зарлигаар уг үсгийг төрийн үсэг болгож, улсын бичиг, тамга тэргүүтнийг үйлдсэн хэдий боловч энэхүү бичиг уйгаржин монгол бичиг лугаа адил өргөн дэлгэрч чадаагүй төдөлгүй орхигдсон юм. Пагва лам Хубилай хааны Бурханы шашныг эрхэмлэж буй үйл ажиллагааг дэмжих үүднээс “Чакраварти” буюу “Номын хүрдэн орчуулагч хаан” хэмээн өргөмжилсөн явдал нь үнэндээ Бурханы шашныг Юань улсын төрийн бодлого болгох гэсэн хэрэг байлаа.

Хубилай хаан аль нэг шашныг онцгойлон үзэж нэгийг хэрэггүй гэж таягдан хаях, нөгөөг нь хэрэгтэй гэж онцгойлон тахидаггүй байжээ. Тэрээр 1266 оны 2-р сард түшмэл Чжан Дэхуйгаас ийнхүү асуусан гэж Инжинашийн “Хөх судар”-т гарч байна. “Манай Монгол улс мандах эртний үед эртний Ляо улс Бурханы сургаалыг гүн шүтснээс мөхөж, Алтан улс бичгийн эрдмийг эрхэмлэснээс мөхөв гэж ярилцаж байхыг би олонтоо сонссон билээ. Ном судар, Бурханы шашин гэгч төр засагт харшилж, улс гэрийг мөхөөх ёс бий юу? гэхэд Чжан Дэхуй хариу өгүүлрүүн: “Ляо улсын төрийн төрийн эрхийг баригчид нь цөм түшмэдийн үр угсаа бөгөөд Алтан улсын засгийг эрхэлсэн нь язгууртан ноёд болой. Энэ хоёр улсын эрх баригчид нь цөм үе улиран залгамжлах хэргэм зэрэгтэн билээ. Тэдний дунд ганц хоёр бичгийн түшмэл бий боловч тэд аймшиггүй төрийг шүүмжилж чадахгүй байжухай. Алтан улс мөхсөн нь тушаалтнаа ялласнаас гэм болжихай” гэхэд Хубилай түүний үгийг зөв хэмээгээд зарлиг буулгасан нь “Шагимунийн сургаал нь хүнийг номхон дөлгөөн болгомуй. Күнзийн сургаал нь хүний биеийг тэгшитгэмүй. Цөм сайн зан бөгөөтөл ертөнцийг тэнцүү захирч эс чадагсад нэгийг нь мандуулж, нөгөөг нь орхигдуулаад алдаж осолдохын эх болгожээ. Би ном, бичгийг хамтаар

⁷⁴ Ш.Бира. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. III Дэвтэр. Хубилай хаан ба Пагва лам. 159-160-р тал.

хэрэглэвч ертөнцийн ёсноос үл хэлтрүүлмүй. Шагимуни, Күнзийн аль нэг нь буй аваас тэр магад чөдөр тушаа болж, их хэрэг бүтэхэд хор болмуй. Манай улс их энхжин жаргасан цагт лав Шагимунийн ёсонд гүн сүсэглэн автах биз”⁷⁵ гэсэн байна.

Хубилай хаан 1264 онд Шанду хотод байхдаа “Сувдан зарлиг” гэгч хууль боловсруулж гаргасан юм. Түүндээ Бурханы шашны талаар явуулж байсан бодлогыг нилээд тодорхой гаргасан байна. “Сувдан зарлиг бичигт: Шашин номын ёсоор явагч Бурханы шашны лам нар Монголын их хаанд дуулгавартай захирагдан, тэднийг өртөө улаа, алба гувчуураас бүрмөсөн чөлөөлөх болно. Бурханы шашны сүм хийдэд элч буух, сүм хийдийн харъяат газар ус, эд хөрөнгийг эдлэж эзэмшихийг хатуу хориглоно гэх мэтээр дурьджээ.⁷⁶ Энэ мэтчилэн Төвдийн Бурханы шашны үйл ажиллагааг Хубилай хаан дэмжсний үр дүн нь Юань гүрний дараачийн хаадуудад ч залгамжлагдсан юм.

Юань гүрэнд Бурханы шашин дэлгэрүүлэхийн тул Пагва олон тооны захидал, сургаал, ном, зохиол бичсэн нь түүний бүрэн зохиолын эмхтгэл болон үлдсэн юм. “Пагва лам Хубилай хаантай уулзахдаа “хүнийг хэрэглэх болвоос өөрөө сонсогтун. Цэрэг, иргэн бүгд хавсарч хар, шарыг (лам ба иргэд) хамтаар хэрэглэмой” гэж хэлжээ. Чухам ингэж Пагва лам “Төр ба шашин номын хоёр ёсон” буюу төр, шашныг хослон барих бодлогыг Хубилай хааны үед үүсгэн явуулах хэрэгт маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм.⁷⁷

Пагва лам хэрхэн таалал болсон тухай “Юан ши” сударт өгүүлснийг энд тодруулж болно: “Пагва ламын бие муудахад Хубилай хааны зарлигаар найман зуу гаруй лам хуврагыг Түмэн амгалангийн сүмд оруулж, Пагва ламын бие тэнхээг сайжруулахыг тэнгэр бурханд даатгаж Бурханы ном хуруулсан”⁷⁸ боловч төдийлөн сайжралгүй, 1279 онд таалал төгссөн юм.

Энэ үеийн Төвдийн Бурханы шашны үндсэн салбар нь Сажийн ёс байсан ба Хубилай хааны тусламжтайгаар энэхүү салбар Юань гүрэнд өөрийн эрх мэдлээ батжуулахын хамт Төвд нутагтаа ч голлох байр суурийг өөртөө бий болгож чадсан юм. Энэхүү Сажа хэмээх Бурханы шашны ёс үүссэн түүхээс энд цухас дурдах аваас Төвдийн умарт зүгийн Сажа буюу орчуулбал, Цайвар шороот гэх нутагт Хон угсааны Гончигжалбуу (1034-1102 он) нь 1073 онд хийд байгуулсан нь хожим Сажа хийд гэж алдаршаад зогсоогүй Бурханы шашны Сажа ёсны урсгал гэсэн нэрээр түүхэнд үлдсэн билээ. Үүнээс хойш дараалан гарсан таван том ламыг Сажийн таван дээдэс гэж Бурханы шашны түүхэнд алдаршин үлдсэн билээ. Үүнд: Сачэн Гунгаанямбуу, Содномзэмо, Дагважанцан, бандида Гунгаажанцан, Догон Чойжал Пагва буюу Пагва лам нар орно.

Энэхүү Төвдийн Сажа ёсны уламжлалын монголчууд хүлээн авсан учир шалтгааны талаар академич Ш.Бира “Сажа хийдийн лам нарын номлож байсан Тантрын ёс нь зарим талаараа монголчуудад илүү ойлгомжтой байв. Түүнийг

⁷⁵ В.Инжинаши. Хөх судар. УБ.2005 он. Дээд боть. 37-39-р тал

⁷⁶ Ч.Далай. Юан гүрний үеийн Монгол. УБ хот. 1973 он. 171-р тал

⁷⁷ Ч.Далай. Юан гүрний үеийн Монгол. УБ хот. 1973 он. 171-р тал

⁷⁸ Су Лянь. Юань улсын судар. I-XI дэвтэр. УБ., 2003. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Цэрэндорж. 10-р дэвтэр

юуны өмнө жирийн монголчууд ч төвөггүй ойлгож байв. Учир нь Тантрын ёс бол төвдүүд Буддын шашныг монголынхтой их төстэй өөрсдийн нийгмийн онцлогт тохируулан авсны үр дагавар байсан ажээ. Төвдийн Бурханы шашин бол Бон хэмээх нутгийн уугуул шүтлэгээс ихээхэн зүйлийг өөртөө шингээн авсан байдаг бөгөөд Тантрын ёс нь Бон шүтлэгийн элдэв ер бусын ид шидэд итгэдэг бишрэлийг хүлээн зөвшөөрсны хувьд бөө шүтлэгтэй монголчуудад илүү ойр дотно байсан байна. Үүнээс гадна Төвдийн лам нар ялангуяа Сажа хийдийн лам нар нь төрийн эрх баригчидтай идэвхтэйгээр хамтран ажиллахыг чухалчилдаг Буддын сургаалын эртний уламжлалыг хатуу баримтлан, тухайн нөхцөлд тэдний хувьд Төвдийн үндэсний эрх ашигтай зөрчилдөх эсэхийг үл харгалзан өөрийн ашиг тусын тулд Монголын хаадтай хамтран ажиллахыг эрмэлзэж байсан нь монголчуудад ихээхэн ашигтай байв” гэсэн байна.

Бурханы шашны хоёрдугаар удаагийн дэлгэрэлтийн үндсэн онцлог нь Юань гүрний хаадын дэмжлэг авч үүгээрээ Төвдийн шашинд Юань гүрний зүгээс дэмжих дэмжлэгэ авахын нөгөө талд урт удаа хугацаанд аян дайн хийж байсан монголчууд нүглээ наманчилж цайруулах боломж олгожээ. Үүний зэрэгцээ монголчуудын хувьд хятадын шашны соёлын гадна үлдэх төрийн бодлого байсан тул тусгаар тогтнолын ач холбогдолтой байсан талаар олон судлаачид нэгэнт бичснийг энд дурдалтай.

Нэгэнт Пагва лам энэ ёсны багш учир Хубилай хаан Сажа хийдтэй өргөн дэлгэр харилцаатай байх бодлого баримталж байсан төдийгүй Хубилай хааны үеэс эхлэн нийслэл хот Хаан балгас болон Ланьжоу зэрэг хотуудад Бурханы шашны сүм хийд, суварга зэргийг шинээр байгуулах зэрэг ажлыг олноор хийж байлаа. “Мөн Бурханы шашны олон судар зохиолыг монголоор орчуулан нийтлүүлэх ажил хийжээ. 1291 оны байдлаар Юань гүрний дотор төрөл бүрийн шашны сүм 42,318 болон лам нар 213,148 байжээ.⁷⁹ Сүүлийн үед Хятадад Юань гүрний Бурханы шашны соёлын судалгаа нилээд эрчимтэй явагдаж байгаа энд цухас дурьдсу.

Энэхүү сэдэвтэй холбогдуулж Юань гүрний төрийн бодлогонд Бурханы шашны хос ёсны бодлого хэрхэн тусгагдаж байсныг нэгэн жишээнд тулгуурлан тайлбарлаж болно. Эртний Энэтхэгийн Ашока, Канишка зэрэг хаад Бурханы шашинд орсноор төрийн бодлогод Бурханы үзэл санааг шингээж өгсөн бодлого хэрэгжиж байсан гэдэг. Үүнийг хос ёс буюу хоёр ёс гэж томъёолсон нь Энэтхэгийн төрийн түүхэнд орсон байдаг. Үүний гол үндэс нь төр, шашныг хослон барих буюу Бурханы энэрэн нигүүлсэхүйд суурилсан бодлогыг баримтлах гэсэн бодлого юм.

Монголын төрийн түүхэнд гарч байсан энэхүү сургаалын мөн чанарыг судлахдаа эрдэмтэд “Цагаан түүх” хэмээх XIII зууны төгсгөл буюу Хубилай хааны үед зохиогдсон гэж үздэг энэхүү эх сурвалжийг иш үндэс болгодог. Академич Ш.Бирагын ажиглалтаар “Цагаан түүх-нд Пагва ламын зохиолуудаас

⁷⁹ Ч.Далай. Юан гүрний үеийн Монгол. УБ хот. 1973 он. 172-р тал.

нэр заан дурьдаагүй боловч Хубилай хааны үеийн “Хоёр ёс”-ны тухай бичсэн энэхүү монгол номыг зохиоход Пагва ламын зохиолууд гол сурвалж болсон хэмээн үзэх нь илүү үндэслэлтэй байгаа юм”⁸⁰ гэсэн саналыг дэмжиж байна. Энэхүү “Цагаан түүх”-нд “лам багшаа оройдоо өргө, эцэг, эхээ мөрөндөө өргө, ядам бурханыг зүрхэндээ сэтгэ, хамаг амьтныг амраг хөвгүүн мэт сэтгэ...”⁸¹ гэх мэтчилэн бичснээс үзэхэд Бурханы шашны энэхүү дэлгэрэлтийн хуульчилж баталсан журам нь тодорхой харагдаж байна. “Цагаан түүх” нь Юань гүрний монгол, түрэг, араб, хятад, зүрчид гэх зэрэг тус улсын дөрвөн зэрэг дивд хамаарах гарын авлага байсан байх үндэслэлтэй.

3. Хубилайгаас хойшхи хаадын Бурханы шашны бодлого

Юань гүрний дараагын хаад Хубилай хааны үед хэвшиж тогтсон шашин, төрийн хос ёсны бодлогыг үргэлжүүлэн баримтлахдаа өмнө тогтсон хэв загварыг ашиглан уламжлуулах байдлаар залгамжилжлагдсан юм. Энэ хандлага олон зүйлд янз бүрийн байдлаар илэрч байсанд нэг жишээ авч болох юм. “Хубилайн үеэс хаан хөвгүүний эрх, үүрэг их болж, түүний ажил төрөл нь тодорхой болжээ. Хаан хөвгүүнийг урьдаас тохоон томилдог нь нэгэн талаар хаан ширээ булаалдах тэмцлээс сэргэмжилсэн тал байвч, нөгөө талаар үндсэн монгол орныхоо төрийн хэргийг бариулах гэсэн учиртай байжээ. Хубилай бол Юань гүрний хаан, хаан хөвгүүн бол Монголын хэргийг ерөнхийлөн захирах хан байсан байна. Хубилай хааны үед тогтсон энэ журам Юань гүрний эцэс хүртэл хэвээр байжээ”⁸². Яг үүнтэй адил Бурханы шашны Сажа ёсны лам хуврагууд Юань гүрний дараагын хаадуудын үед өөрсдийн эрх мэдэл байр сууриа залгамжлан хадгалж чадсан юм.

Пагва ламаас хойш хэд хэдэн лам Юань улсын хаадын зарлигаар улсын багшаар өргөмжлөгдсөн байна. Үүнд нэгэн ламыг энд иш татаж болох юм. Дарамбала хааны хүү Хайсанхүлэг хаан ширээнд сууж байхдаа “хамгийг айлдагч Чойгу Одсэрийг залж, өргөл хүндлэл агуу их үйлдэв. Энэ лам урьд Сажа Банчингийн зохион урласан үсгийн дээр сүүлт олон үсэг нэмж гүйцээн төгсгөөд, их тарни тэргүүтэн зарлиг, шасдир олныг монгол хэлэнд орчуулж, шашин эрдэнийг энэ зүгт арвижуулан дэлгэрүүлэв”⁸³ гэсэн байдаг. Мөн Дармадалагийн “Монголд Бурханы шашин дэлгэрсэн түүх”-нд өгүүлснээр дараах хэдэн жишээг энд дурдаж болно. Буянт хаан “нас идэр, залуу хотол төгс, чин зоригт, баатар, цэцэн, хүчин чадлаар төгс чимсэн, шашинд бишрэнгүй тэргүүтэн эрдэм төгс учир Чим Жамбийян буюу Жамгэг багшийг тахилын оронд залж өргөл хүндлэл агуу ихээр үйлджээ. Энэ лам зохилдохын шалтгааныг барилдуулж Нартангийн Ганжуур, Данжуурын бар бүтээлээ”⁸⁴ гэсэн байна. Энэ

⁸⁰ Ш.Бира. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. III Дэвтэр. Хубилай хаан ба Пагва лам. 163-р тал.

⁸¹ УБ., 2006. Хэвлэлд бэлтгэсэн Ш.Чоймаа. Р.Төрдалай.

⁸² Ч.Далай. Юань гүрний үеийн Монгол. УБ хот. 1973 он. 171-р тал.

⁸³ Дармадала. Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч Цагаан лянхуан эрхис хэмээх оршвой. “Билгийн гэгээ” цуврал. УБ хот. 1995 он. 49-р тал.

⁸⁴ Дармадала. Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч Цагаан лянхуан эрхис хэмээх оршвой. “Билгийн гэгээ” цуврал. УБ хот. 1995 он. 49-р тал.

ЦАХАР ГЭВШИЙН СУДАЛГААНД НЭМЭРЛЭХ НЬ

Б.Түшихбаяр - МУИС.НШУС, Шашин Судлалын Тэнхимийн докторант

Түлхүүр үг: Цахар гэвш, Хөвөөт Цагаан нуурын хошуу, сонсох - санах – бясалгах, Юнхэгүний хийд.

Товч утга: Энэхүү өгүүлэлд судлаач Монголын мэргэдийн дунд Цахар гэвш хэмээн алдаршсан Лувсанцүлтэмийн амьдрал, уран бүтээлийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлсэн байна. Үүний тулд судлаачдын хандлагыг дурьдахын хамт түүний намтрыг гурван хэсэгт хуваах санал тавьж, уран бүтээлийнх тухайд “Богд Зонхавын намтар” бүтээлд нь жишээ авч танилцуулжээ.

Монголын мэргэдийн дунд ихээхэн алдаршсан эрдэмтэдийн нэг нь Цахар нутгийнхаа нэрээр түүхэнд алдаршин үлдсэн Цахар гэвш Лувсанцүлтэм юм. Тэрээр Өвөр монголын Цахар хошууны нутаг дахь Сайхан нуур хэмээх газарт малчин айлын гэрт мэндэлсэн хэдий боловч улмаар лам болж сүм хийдийн хүрээнд бүхий л амьдралаа өнгөрүүлж, энэ хугацаандаа шүлэг зохиол бичих, ном судар орчуулах ажлыг далайцтай хийсэн ба түүний сүмбум нь 10 боть, 215 бүтээлээс бүрддэг юм. Сүмбумд нь ихэнх нь орсон боловч мөн ороогүй бүтээл ч бас үлдсэн тухай судлаачид тодруулсан байдаг.

Намтар судлалын товчоон

Цахар гэвш Лувсанцүлтэм (1740-1810 он) нь үндсэндээ XVII зууны сүүл үед амьдарч байсан хүн бөгөөд зохиол бүтээл нь гар бичмэл, барын судрын хэлбэрээр Ар, Өвөр Монголын нутагт тархаж энэ үед хүрч ирсэн юм. Энэхүү ламын талаар XX зууны дунд үеэс судалгаа эхэлсэн бөгөөд түүний намтар, уран бүтээлийн талаар Ц.Дамдинсүрэн⁸⁶, Ш.Бира⁸⁷, В.Хайссиг⁸⁸, Ч.Алтангэрэл⁸⁹, Оч⁹⁰, Л.Хүрэлбаатар⁹¹, Д.Цэрэнсодном⁹², Д.Дагвадорж⁹³, Б.Саранцэцэг, Б.Амбага, Ш.Болд⁹⁴ нарын судлаачид тодорхой хувь нэмэр оруулжээ.

Цахар гэвш Лувсанцүлтэмийн намтар судлалын холбогдолтой эх сурвалжаас энд тодруулж болно. Үүнд: түүний ойрын шавь Лувсансандүвнямийн 1817 онд бичиж үлдээсэн “Гэтэлгэгч дээд лам адилтгал үгүй ачит богд Сумадишилашрибадрагийн гэгээний ерөнхий зохиол намтрыг товч төдий өгүүлсэн сүсгийн лянхуаг мишээлгэгч нэрт гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив” гэх төвд, монгол хэлээр нийтлэгдсэн

⁸⁶ Ц.Дамдинсүрэн. “Монголын уран зохиолын тойм”. 1 дэвтэр. УБ. 1957.⁸⁶ Ц.Дамдинсүрэн. Д.Цэнд.

⁸⁷ Монголын уран зохиолын тойм. 2 дэвтэр. УБ. 1976.

⁸⁸ Ш.Бира. Монгольская историография. XIII-XVII вв. Москва. 1978

⁸⁹ W.Heissig. Geschichte der Mongolischen Literatur, Band I, II. Wiesbaden.

⁹⁰ Ч.Алтангэрэл. Монголын зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл. II дэвтэр. УБ. 1967.

⁹¹ Очи. Цахар гэвш. Лувсанцүлтэм. Ардын хэвлэлийн хороо. Бээжин. 1993 он.

⁹² Д.Цэрэнсодном. Монгол уран зохиолын. УБ. 1987. Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ. 1997.

⁹³ Д.Дагвадорж. Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цомирлог. УБ. 1998.

⁹⁴ Б. Саранцэцэг, Б.Амбага, Ш.Болд. Монголын анагаах ухааны мэргэдийн товчоон. УБ. 1999. Ш.Болд. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ. 2005 он

намтар зохиолыг академич Ш.Бира⁹⁵ судалгаандаа ашигласан байна. Мөн академич Д.Цэрэнсодном "1960 хэдэн онд Доржжанцан ламыг Гандангийн Номын санг эрхэлж байх үед үед энэ намтар байсан боловч төдөлгүй үгүй болоод хориод жил болж байна"⁹⁶ гэж дурдсан байдаг. Энэ намтрын өөр нэг эх нь Өвөр Монголын Номын санд хадгалагдаж байгаа гэсэн мэдээ бий.⁹⁷ Энэхүү намтар нь таван зуу шахам тал бүхий долоон бүлэг томоохон намтар тул Цахар гэвшийн намтрыг маш дэлгэрэнгүй танилцуулсан юм. Энэхүү намтрыг манай олон судлаачид баримтлан судлаж ирсэн байна. Тухайлбал, Ш.Бира "Монгольская историография" бүтээлдээ ашигласныг нь хожим судлаачид дамжуулан авсан бололтой байна. Мөн доктор Д.Дагвадорж "Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг"⁹⁸ бүтээлдээ дээрх намтрын нэг хувилбарыг авч судлан бичсэн байна. Тухайлбал, сүүлчийн хувилбарт Д.Дагвадорж тодорхойлохдоо: "1918 онд төвд, монгол эхээр хэвлүүлжээ" гэсэн байхын хамт зохиогчийн нэрийг Лувсансандүвням гэхийг Лувсансанровням гэж бичсэн нь зэрэг нь нэг эхийн хоёр хувилбар болохыг харуулж байна. Үүнээс өөр намтар судлаачидад олдоогүй тул үүнийг баримтлан олон судлаачид өөр өөрийн хувилбараар тодорхойлон бичсэн байх ажээ.

а. Эхэн үеийн намтарЦахар гэвш Лувсанцүлтэм нь одоогийн Өвөр Монголын Цахар найман хошууны нэг Хөвөөт цагаан хошууны нутагт Сайхан хэмээх нуурын баруун хөвөөнд XII жарны төмөр бичин жил (1740 он) малчин Цэгонжалын ууган хүү болон мэндэлжээ. Түүний ээж Намбаржалжид нь энэхүү том хүүгээ гаргаад дараа нь 7 хүүхэд гаргасан ба эднийх бүгд 8 хүүхэдтэй айл байжээ.

Ингээд "Цахар гэвш" гэж алдарсны уг шалтгааныг энд тодруулах нь зүйтэй юм. Өвөр Монгол нь 49 хошуутай бөгөөд тэдгээрээс Цахарын 8 хошуу гэж байсан ба тэдгээрийн нэг нь энд дурдаж буй Хөвөөт цагаан хошуу юм. Тэрээр нийт Монгол даяар нэрд гарахдаа Цахар гэсэн тодотголтой болжээ. Гэхдээ үнэндээ эдний гэр бүлийн уг гарвалыг хөөн үзвэл энэ нутагт хожуу ирж суурьшсан болох нь тодорхой байна. Энэ талаар Д.Цэрэнсодном судлан тодорхойлсноор "эднийхэн уг нь Ордос Долоон хошуунаас нүүж ирсэн Уйгуд овгийн хүмүүс"⁹⁹ ажээ. Гэвш гэдэг нь Чойрын ном үзэж дамжаа барьж авдаг цол билээ. Цахар гэвш Чойрын дацанд сууж гэвшийн дамжаа барьсан хүн тул ийнхүү нэрлэгджээ. Хуучин цагт гэвш нар нэн олон байсан ба тэр тусмаа Цахарын хошуунд сүм хийд олон байсан зэргээс үзэхэд энэхүү ламын эрдэм онцгой хэтийдээд энэ хоёр үг л энэ ламын нэрийг орлох хүртэл алдаршсан нь тодорхой байгаа юм. Мөн түүний намтрын гарчигт гарч байгаа Сумадишилашрибадра гэсэн нэрийг энд тодруулах нь зүйтэй. Цахар гэвш нэрээр ойр хавийн нутагт алдаршсан боловч өөрийнхөө бүтээлд дээрх нэрээр олонтоо нэрээ тавьсан байдгаас намтрыг бичигч энэ нэрээр гаргасан байна.

⁹⁵ Ш.Бира. Монгольская историография. XIII-XVII вв. Москва. 1978

⁹⁶ Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ. 1997. 125-р тал

⁹⁷ Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ. 1997. 385-р тал

⁹⁸ Д.Дагвадорж "Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. УБ. 1998. 111-р тал

⁹⁹ Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ. 1997. 125-р тал

Энэ нь санскрит үг бөгөөд орчуулбал, “Утга төгөлдөр ариун тойн” гэсэн үг ажээ. Лувсанцүлтэм ийм утга зохиолын нууц нэр бүтээлдээ олонтоо хэрэглэсэн байдаг юм.

Цахар гэвш сүм хийдийн боловсрол эзэмшихээсээ өмнө үндэсний эх бичигт суралцаж иргэний боловсрол сайтар эзэмшсэн нь түүний хожмийн нэр алдарт хүрэх нэгэн шижим байсан байж болох талтай юм. Түүнд нь авга ах Хужим нь монгол бичиг зааж уншиж сургасан байна. Энэ үеийнхний нэгэн адил энэ үеэс Энэтхэг, Төвд, Монголын дээдсийн сургаалт зохиол, үлгэр, туужтай танилцсан нь тодорхой. “Намтарт тэмдэглэснээр Лувсанцүлтэм бага наснаас сэргэлэн цовоо, сурах эрдэмд шамдалтай, номын бясалгалд үнэн сүжигтэй нэгэн байжээ”¹⁰⁰. Долоон настайдаа сүм хийдэд шавилан буяны садан Чайв хутагт Эрдэнэлувсанпэрэнлэй гэгээнээс увш (гэнин) санваар, 15 настайдаа ачит номун хан Лувсанданзангаас гэгцэл санваар, 16 настайдаа Бодь тив сүмийн ширээт лам Лувсандамбийнямаас гэлэн санваар тус тус авснаар Бурханы шашны номын ёсыг эргэлт буцалтгүй хөөх болсон байна. Шарын шашны ёсонд “бусдыг хорлохын уг суурь лугаа сэлтийг тэвчиж цалгайрсан ёс цаазын үргэлжлэлийг боон хаахыг санваар”¹⁰¹ гэж эрхэмлэн үзэх ба шашин оршин тогтохын ёс гэж үзэх тул ийнхүү энэхүү намтрын эхэнд нь оруулж байна. Тэрээр өөрөө сахил санваарын ёсыг хатуу баримтлахыг нэн анхаарч байсан дараах нэгэн жишээнээс тодорхой. Тэрээр “шашин хэмээгч нь ямар юм бэ? гэвэл зөв ёсыг хэлнэ. Тэр нь Бурханы номлосон “Винайн эш” сударт өгүүлснээр “ямарваа хилэнцийг үл үйлдэх ба буяныг хотол төгсөөр эдлэх болон өөрийн сэтгэл юүгээн огоот нохтгох, энэ Бурханы шашин хэмээн номлосон”¹⁰² гэж бичсэнээс нь харагддаг. Энэ үг нь зөвхөн иш татсан үг төдий бус түүний амьдралд винайн ёс горим сахил авах үеэс эхлэн насан турш хатуу баримтлах ёс горим болсон байсан гэх үндэс юм.

Б. Дунд ба сүүл үеийн намтрыг сонсох, санах, бясалгах гуравтай холбох нь. Бурханы шашинд Бодь мөрийн зэргийн хөтөлбөр нь аливаа хуврага лам хүний амьдралдаа хэрэгжүүлэх ёстой хамгийн гол гарын авлага байдаг билээ. Иймээс Цахар гэвш Лувсанцүлтэмийн намтрын дунд ба сүүл үеийн байдлыг сонсох, санах бясалгах гуравтай холбон тайлбарлаж болох юм. Энэ нь анх Бурханы шашны шавь болохоос багшаас номын хөтөлбөр сонсох, цээжлэх, утга санааг өөрийн сэтгэлд барилдуулан дадуулах зэргээр суралцах үе шатыг хэлдэг юм.

Тэрээр өөрийн авъяас билгээ шашны ёсны ном сургаалыг эзэмшихэд зориулан Цахарын хөвөөт цагаан хошуундаа эхлээд Бодь тив сүмд шавь орж анхан шатны боловсрол эзэмшсэн юм. Энэ үед тэрээр Бодь төв сүмийн чайв Хутагт эрдэнэ Лувсанпэрэнлэй түүнд гэнин сахил өргөхдөө Лувсанцүлтэм гэх сахилын нэр авсан байна. Орчин үеийн судлаачдын намтрын судалгаануудаас

¹⁰¹ Буддын шашин, соёлын тайлбар толь. УБ.2000. 211-р тал.

¹⁰² Д.Дагвадорж “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг.УБ.1998. 119-р тал.

үзэхэд түүний эцэг, эхээс анх өгсөн нэр гарахгүй харин Лувсанцүлтэм гэсэн сахилынх нь нэрээр нэрлэж хэвшсэн зүйл ажиглагдаж байгаа юм. 15 настайдаа Долоон нуурын хийдэд очиж, Шийрэвранжамба, Балам Лувсан нараас мөрийн зэргийн хөтөлбөр, итгэлийн хөтөлбөр зэргийг сонсож, улмаар судар, тарнийн ном ухаанд суралцах болсон юм. Тэрээр энэ тухайгаа "Тэр цагт би бээр сургуулилан үйлдэхдээ шамдах сэтгэл гүн их тул шөнийг дуустал судар номоо үзэх бодох, цээжлэхийг үйлдсээр үүр цайлгаж одох нь олонтой байсан"¹⁰³ гэж дурдсан байдаг.

"Улмаар 1762 оны үеэс Юнхэгүний хийдийн цанид дацанд хурж, тухайн үедээ ихэд нэрд гарсан мэргэн гүүш Агваанринчен, Мянган равжамба, цорж Донров Ажаа хутагт Лувсандамбийжалцан, Жанжаа хутагт Ролбийдорж нараар ном заалган"¹⁰⁴ тэдний итгэлийг хүлээх болжээ. Тэрээр энэхүү хийдэд долоон жил суусан ба энэ хугацаанд хийж гүйцэтгэсэн нэг гол ажил нь Ажаа хутагтын тэргүүлж байсан орчуулгын хэсгийн бүрэлдхүүнд орж түүний бүрэн эмхтгэлийг хэвлэн гаргаж байжээ. Энэ үед тэрээр орчуулгын өндөр ур чадвартай бэлтгэл хангагдсан болох нь тодорхой. Тэрээр 1767 онд 27 настайдаа цанидын номын гэвшийн дамжаа барьсан юм. Ингээд тэрээр нутаг орондоо буцаж хуучин хийддээ хурах хүсэлт гаргасан тус хийдийн ажил үйлс их байснаас дараа жил нь зөвшөөрөл олджээ.

31 настайдаа Долоон нуураас өөрийн хошуундаа буцан ирж, бясалгал үйлдэх, шүтээний ёсыг сахихын зэрэгцээ хийдийн хуралд сууж байлаа. 38 настайдаа өөрийн хийддээ эргэн ирсэн байна. Түүний нутагтаа очоод хийсэн үйлс явдлыг хэд хэдэн жишээнд танилцуулж болох юм.

1. Сүм дуган бүтээх үйлсэд хувь оруулсан хувь нэмэр. Тэрээр орон нутгийнхаа сүм хийдийг бүтээх үйлсэд хувь нэмэр оруулж, заавар зөвлөгөө өгөх зэргээр тусалж байсан байна.

2. Сүм хийдийн зан үйл, дэг жаягийг боловсруулах, тогтооход оруулсан хувь нэмэр. Тэрээр зарим уншлагыг монгол хэлээр уншуулах ажлыг удирдан зохиохын зэрэгцээ шавь нарт хурлын уншлага хийгээд уншлагын ая эгшиг, хөгжим үлээх, дэлдэх тэргүүтэнг сургаж гүйцэтгэсэн байна. Энэ үед тэрээр хурлын уншлагын ая данг сайтар мэдэх болсон байсан нь тодорхой.

3. Судар номын төрөл бүрийн үйл хэрэгт оруулсан хувь нэмэр. Үүнд, судар төвд хэлнээс монгол хэл рүү монголоос төвд хэл рүү орчуулах, өөрөө тайлбарлах, зохиох, судрын бар удирдан сийлүүлэх, барлан хэвлүүлж гаргах тэргүүтэн үйлийг эрхэлж байлаа. Энэ тухай судлаач Д.Дагвадорж "зохиох, орчуулах, тайлбарлах гурвыг нэгэн зэрэг хийж байсан нь түүний соён гэгээрүүлэх ажлын үндсийг илэрхийлдэг"¹⁰⁵ гэж үнэлсэн байдаг.

Энэ бүхнээс үзэхэд Цахар гэвш Лувсанцүлтэм бээр Бурханы сургаалыг сонсох, санах, бясалгах гурван үйлийг тасралтгүй хийсэн юм. Энэ тухай түүний

¹⁰³ Д.Дагвадорж "Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг.УБ.1998. 113-р тал

¹⁰⁴ Цахар гэвш Лувсанцүлтим. Богд Зонхавын намтар. УБ.2004 он. Д.Наранцэцэг. Д.Цэрэнсодном. Удиртгал. 22-23-р тал.

¹⁰⁵ Д.Дагвадорж "Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг.УБ.1998. 112-р тал

шавь Лувсансандүвнямын бичсэн намтарт өгүүлж буйгаар “цанидын дүйрэгээс эхлэн далай мэт их гол асуудал сонсох судлах сургууль хийгээд авралын дээд богд Ажаа гэгээнтний дэргэдээс хязгааргүй олон судар тарнийн ёсыг олсон тэргүүтнээр... төгсгөөд гүн бөгөөд агуу их далай мэт гол ёсуудын чанад хрүч, бодь мөрийн зэргийн оньс бүгдийг нь сэтгэлдээ сайтар багтаасан”¹⁰⁶ юм.

2. Бүтээн туурвисан бүтээлийн товч тойм

Цахар гэвш Лувсанцүлтэмийн сүмбумд өмнө өгүүлсэнчлэн 10 боть, 215 бүтээл орох боловч өөрийнх нь намтарт бичснээр “сумбумыг эвлүүлэн түгээхүйн үед эх эвхмэл цаас эс олдсноор сумбумын дотор эс орсон ч байх амой”¹⁰⁷ хэмээн дурссан байдаг нь бард сийлэн хэвлэх үед цаасны хомсдлоос зарим бүтээл орхигдсныг хэлж байна. Энэ тухай академич Д.Дагвадорж олж тодорхойлсноор “ялангуяа, од, гаригын орчих замын шинжүүд, эм татах, найруулах ёс хийгээд гүн ухааны тайлбар зохиол болох дундад үзлийн ба шалгадаг ухааны ном энд багтана”¹⁰⁸ гэсэн байна.

Түүний бүтээлээс бидэнд мэдэгдэж байгаа зарим гол бүтээлүүдээс энд дурдаж болох юм. Тэрээр “Илт онолын чимгийн тайлбар, арван бүлэгт”, “Бодь мөрийн зэргийн дөрвөн их тийн агуулал, оньсны утгыг гийгүүлэгч”, “Махбод болон махбодоос болсон ойлголтыг тайлахуй”, “Сэтгэл үүсэхийн шинжлэл”, “Орчлонгийн сав, шимийн дуулал”, “Төвдөд Винайн ёс гарсан ёс”, “Эрдэнэ дөшийн сүмийн хөх дэвтэр”, “Сангаарагчаагын тууж оршвой”, “Амрагийн тэнгэрийн зарим зовлонг санах ёсны судар”, “Дошинжийн (Энхжингийн) домог үйл үрийн дүрс хөргийг тодорхой үзүүлсэн хиргүй толь”, “Дээд номд орох ёсон”, “16 найдангийн ялгавар”, “Хамгийг айлдагч богд Зонхавын цадиг мэдэхүйеэ хялбараар өгүүлсэн сайн амгалан бүхэн гарахын орон хэмээгдэх оршвой”, “Сухавадийн орны зохиолыг өгүүлсэн үг, ариун орны эрдмийг тодорхой өгүүлэх билгийн толь” гэх мэт хориод бүтээлийн гарчиг мэдэгдэж байна.

Тэдгээрээс Д.Дагвадорж “Махбод ба махбодоос болсон тэргүүтний ойлголтыг тайлахуй” бүтээл дэхь дүрс цогцийн гол ёс ба дүрст цогцыг танин барихуй гэсэн асуудалд гүн ухааны шинжилгээ хийсэн юм.¹⁰⁹ Мөн академич Д.Цэрэнсодном ““Сухавадийн орны зохиолыг өгүүлсэн үг, ариун орны эрдмийг тодорхой өгүүлэх билгийн толь”¹¹⁰, “Хамгийг айлдагч богд Зонхавын цадиг мэдэхүйеэ хялбараар өгүүлсэн сайн амгалан бүхэн гарахын орон хэмээгдэх оршвой”¹¹¹, “Эрдэнэ дөшийн сүмийн хөх дэвтэр”¹¹² зэрэг гурван бүтээлд

¹⁰⁶ Лувсансандүвням. “Гэтэлгэгч дээд лам адилтгал үгүй ачит богд Сумадишилашрибадрагийн гэгээний ерөнхий зохиол намтрыг товч төдий өгүүлсэн сүсгийн лянхуаг мишээлгэгч нэрт гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив”

¹⁰⁷ Лувсансандүвням. “Гэтэлгэгч дээд лам адилтгал үгүй ачит богд Сумадишилашрибадрагийн гэгээний ерөнхий зохиол намтрыг товч төдий өгүүлсэн сүсгийн лянхуаг мишээлгэгч нэрт гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив”

¹⁰⁸ Д.Дагвадорж “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. УБ.1998. 112-р тал

¹⁰⁹ Д.Дагвадорж “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. УБ.1998. 121-126-р тал

¹¹⁰ Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ.1997. 126-137-р тал

¹¹¹ Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ.1997. 137-144-р тал

¹¹² Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ.1997. 188-213-р тал

шинжилгээ хийхийн зэрэгцээ “Хамгийг айлдагч богд Зонхавын цадиг мэдэхүйеэ хялбараар өгүүлсэн сайн амгалан бүхэн гарахын орон хэмээгдэх оршвой”¹¹³ бүтээлийг ариутган шүүж хэвлүүлсэн байна.

а. “Хамгийг айлдагч богд Зонхавын цадиг мэдэхүйеэ хялбараар өгүүлсэн сайн амгалан бүхэн гарахын орон хэмээгдэх оршвой” бүтээлийн тухай

Энэ бүтээлийг академич Д. Цэрэнсодном санаачилан ариутган шүүж, докторант Д.Наранцэцэг хуучин монгол бичгийн эхээс сийрүүлэн буулгаж, тайлбар сэлт хийж 2004 онд хэвлэн гаргаж судалгааны эргэлтэнд оруулснаар судлаачид төдийгүй олон нийт уг зохиолтой танилцсан юм. Энэхүү Богд Зонхавын намтар нь 9 бүлэгтэй томоохон зохиол юм.

Энэ бүтээл нь Шарын шашныг үндэслэгч богд Зонхавын (1357-1419 он) намтрыг өргөн дэлгэр гаргасанаараа Төвд, Монголын мэргэдийн дунд асар их алдаршжээ. Энэ зохиолыг Цахар гэвш 47-ны сүүдрийн улаан морин жил туурвиж эхлээд 51-ний сүүдэр зооглосон цагаан нохой жил сүүлчийг нь бичиж дуусгажээ. Судлаач Д.Дагвадорж “Энэ бол түүний бүтээлийн оргил” гэж үнэлсэн бол Өвөр Монголын судлаач Дэлгэрсайхан “Амдуу, Төвдийг донсолгосон амжилттай бүтээл болсон”¹¹⁴ гэсэн байдаг. Энэ талаар Д.Дагвадорж тайлбарлахдаа “учир нь Зонхавын төрсөн нутаг Гүмбум хийдийн ба Лхасын гурван хийдийн эрдэмтэн нар гүйцэтгэж амжаагүй үед уул намтрыг монгол, төвд хэлээр зохион барласантай холбоотой юм”¹¹⁵

Энд өөрийн сонссон зүйлийг оруулж болно. Цахар гэвшийн намтар төвдүүдийн бичсэн намтраас илүү том хэмжээтэй болсон тул яаж ийм том болсныг нь Цахар гэвшээс асуусанд Богд Зонхавыг бясалгаж, түүнтэй нигуур тулан уулзаж аман айлдварыг нь авч дэлгэрүүлэн бичсэн гэж хэлсэн гэсэн домог байдаг юм. Цахар гэвшийн намтраас том хэмжээтэй богд Зонхавын намтар хуучин цагт Төвд, Монголд гараагүй байна.

3. Түүний бүтээлүүдийн нь туурвил зүйн онцлог

Цахар гэвш Лувсанцүлтэмийн туурвил зүйд ажиглалт хийхэд түүний хэл найруулга бусад олон зохиолчдийн найруулгаас өөрийн онцлогоор ялгардаг. Энэ тухай судлаачдын зарим дүгнэлтийг авч үзье. Энэ талаар орчин үеийн судлаачдаас анх түрүүн ажиглалтыг Ц.Дамдинсүрэн хийсэн юм. Тэрээр “Цахар гэвшийн зохиолын чухал нэгэн тал нь өргөн олон монгол уншигчдад чиглэгдсэн гэдгийг мэдэж болно”¹¹⁶ гэсэн нь орчин үеийн хялбаршуулсан найруулгатай зохиолын хэмжээнд туурвих оролдлого хийж байсан гэж үзэж болохоор байгаа юм. Энэ тухай Ц.Дамдинсүрэн цааш нь “Өөрийн энэхүү зорилгоо биелүүлэхийн биелүүлэхийн төлөө нилээд олон тооны зохиолыг орчуулан хэвлэсэн байдаг.

¹¹³ Цахар гэвш Лувсанцүлтим, Богд Зонхавын намтар, УБ.2004 он, Д.Наранцэцэг, ариутган шүүсэн Д.Цэрэнсодном

¹¹⁴ Эрт ойр үеийн монгол зохиолч хийгээд монгол зохиол, Ардын хэвлэлийн хороо, 1987, 57-р тал.

¹¹⁵ Д.Дагвадорж “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг, УБ.1998, 112-р тал

¹¹⁶ Ц.Дамдинсүрэн, Цахар гэвшийн үйл ажиллагааны зарим онцлогийн тухай, Монгол судлал, УБ. 1975, 2 (10)

Тэдгээр нь ард олны урам зоригийг татдаг, уншихад ойлгомжтой зохиолууд бөгөөд ерөнхийдөө шашны агуулгатай зохиол биш, харин иргэний чиглэлтэй бүтээлүүд болно”¹¹⁷ гэсэн байна. Үүнтэй холбогдуулж Д.Цэрэнсодном “Цахар гэвш Буддын уран зохиолын олон чухал дурсгал бичгийг монгол хэлнээ яруу тансаг орчуулж дундад зууны үеийн Монголын орчуулгын түүхэнд шинэчлэл хийсэн” гэсэн дүгнэлт гаргасан байдаг¹¹⁸.

Мөн тэрээр Богд Зонхавын намтар бүтээлийн туурвил зүйн тухайд “Цахар гэвш Богд Зонхавын намтрыг цулгүй түүхчилэн өгүүлсэнгүй тахил төгсгөл, завсар үеийн шүлэг, өөрийнх нь сургаал найраг элдэв домог үг тэргүүтнээр хачирлан туурвилзүйн өндөр түвшинд бичсэн нь үнэнхүү бишрэлийг төрүүлдэг билээ”¹¹⁹ гэсэн байдаг.

Доктор Д.Дагвадорж “Цахар гэвш уран зохиолд авъяастай, түүхийн ба гүн ухааны өргөн мэдлэгтэй, дорнын ухаанд мэргэшин, эрдэм ухааны олон ном зохиол туурвиснаар Монголын соёлын сан хөмрөгт хувь нэмрээ оруулсан билээ”¹²⁰ гэсэн байна.

Цахар гэвш судлалыг цаашид өргөжүүлэх шаардлагатай

Цахар гэвш судлалыг хөгжүүлэхэд юуны өмнө эх бүтээлийг бүртгэн эмхтгэх, орчуулах, энэ талын Өвөр Монголын сүүлийн үеийн судлаачдийн шинжилгээний бүтээлүүдэд түшиглэх шаардлага байна. Ийм ажил эдүгээ хүртэл хийгдээгүй тул энэ талын судалгаа бүрэн гүйцэт болох боломж хомсхон байна.

Сүүлийн хориод жилд гарсан судалгааны гол нь Д.Цэрэнсодномын “Бурханы шашны уран зохиол”¹²¹ номонд орсон хэсэг, Д.Дагвадоржийн Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг” бүтээлийн холбогдох хэсэг¹²² гэх зэрэг цөөн тооны бүтээлүүдээс хэтрэхгүй байна.

Д.Цэрэнсодном өмнө өгүүлсэн гурван бүтээлд шинжилгээ хийсэн ба Д.Дагвадорж мөн өмнө өгүүлсэн нэг гүн ухааны бүтээлийн нэг хэсэгт гүн ухааны дүгнэлт хийснээс төдийлөн хэтрэхгүй байна. Д. Дагвадорж “Түүний гүн ухааны зохиолд шинжилгээ хийж, Монголын гүн ухаанд оруулсан хувь нэмрийн талаар тойм төдийхөн ойлголт буй ба цаашид нягтлан судлах нь зүйн хэрэг”¹²³ гэсэн байна. Энэ бүхнээс үзэхэд цаашид Цахар гэвш судлалыг улам сайжруулж, түүний зохиол бүтээлд дэлгэрнгүй иж бүрэн судалгаа хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа билээ.

¹¹⁷ Ц.Дамдинсүрэн. Цахар гэвшийн үйл ажиллагааны зарим онцлогийн тухай. Монгол судлал. УБ. 1975. 2 (10)

¹¹⁸ Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ.1997. 125-р тал.

¹¹⁹ Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ.1997. 189-р тал.

¹²⁰ Д.Дагвадорж “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг.УБ.1998. 113-р тал

¹²¹ Д.Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ.1997. 188-213-р тал

¹²² Д.Дагвадорж “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг.УБ.1998. 121-126-р тал

¹²³ Д.Дагвадорж “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг.УБ.1998. 121-р тал

SUMMARY

When author making his own suggestions about the prominent scholar Tsahar Geshe Luwsan shultem, the author gave the brief introduction on tendency of modern researchers about the scholar simultaneovsly with the biography of the monk and his works.

As he considers it is necessary to study the creations of the Geshe in a profound way.

НОМ ЗҮЙ

1. Ш.Бира. Монгольская историография. XIII-XVII вв. Москва. 1978
2. Д. Цэрэнсодном. Монголын Бурханы шашны уран зохиол. УБ. 1997
3. Д.Дагвадорж "Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. УБ. 1998
4. Буддын шашин, соёлын тайлбар толь. УБ. 2000. 211-р тал
5. Цахар гэвш Лувсанцүлтим. Богд Зонхавын намтар. УБ. 2004 он. Шинэ үсэгт хөрвүүлсэн Д.Наранцэцэг
6. Лувсансандүвням. "Гэтэлгэгч дээд лам адилтгал үгүй ачит богд Сумадишилашрибадрагийн гэгээний ерөнхий зохиол намтрыг товч төдий өгүүлсэн сүсгийн лянхуаг мишээлгэгч нэрт гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив" УБ. 2010 он. Монгол бичгээс хөрвүүлж удиртгал, тайлбар бичсэн Д. Цэрэнсодном, Д.Наранцэцэг.
7. Ц. Дамдинсүрэн. Цахар гэвшийн үйл ажиллагааны зарим онцлогийн тухай. Монгол судлал. УБ. 1975. 2 (10)

Ном зүй

11. Austin J.L. *How to Do Things with Words*. Oxford, 1962
12. Bell D. *The Coming of Post-Industrial Society*. New York, 1973
13. Benamou M & Caramello Ch. (ed.) *Performance in Post Modern Culture*. Wisconsin : Center for XXth Century Studies & Coda Press, 1977
14. Hassan I. *Culture, Indeterminacy, and Immanence: Margins of the (Postmodern) Age // Humanities in Society*. Vol. 1. 1978
15. Hassan I. *The Dismembrement of Orpheus : Toward a Post Modern Literature*. New York : Oxford U.P., 1971.
16. Illich I. *Tools for Conviviality*. N.Y.: Harper & Row, 1973.
17. Jean-Francois Lyotard *The Postmodern Condition: A Report on Knowledge*. University of Minnesota Press, USA, 1984.
18. Medavar P.B. *The Art of the Soluble*. London: Methuen, 6 ed., 1967
19. Neumann J., von, Morgenstern O. *Theory of Games and Economic Behavior*. Princeton U.P., 1954
20. Watzlawick P., Helmick-Beavin J., Jacson D. *Pragmatics of Human Communication. A Study of International Pattrens, Pathologies, and Paradoxes*. N.Y.: Nor-torn, 1967